

Долоо хоног тутмын мэдээ мэдээлэл - Монголын Мянганы сорилтын сан

№2 (11)

2021.03.22



“Усны асуудлыг шийдэж чадсан хэн боловч Нобелийн хоёр шагнал хүртэх эрхтэй - нэг нь Энхтайваны, нөгөө нь Шинжлэх ухааны”

— АНУ-ын 35 дахь Ерөнхийлөгч Жон Кеннеди

УС АШИГЛАЛТ, ОЛБОРЛОЛТЫН ХЭМЖЭЭГ ЗОХИЦУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ БОЛОМЖТОЙ НЭГДСЭН ПОРТАЛЫГ ХҮЛЭЭЛГЭН ӨГЛӨӨ



Дэлхийн банкны дэргэдэх 2030 Усны нөөцийн бүлгийн Монгол дахь хөтөлбөрийн газраас 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдөр Улсын усны хяналт шинжилгээний groundwater.mn нэгдсэн порталыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газарт хүлээлгэн өгсөн байна. Энэхүү Хяналт-Удирдлагын порталыг хөгжүүлж, газрын доорх усны нөөцийн ашиглалт, хамгаалалтын хэтийн төлөвийг тооцох загварчлалыг боловсруулах ажлыг 2030 Усны нөөцийн бүлгийн Монгол болон Энэтхэгийн баг, БОАЖЯ, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар, БНЭУ-ын мэдээлэл технологийн “Блобсити” компани, Монгол Улсын мэдээллийн технологийн “КПМ” компанитай хамтран 2018-2020 оны хооронд

хийж гүйцэтгэжээ. Өнөөгийн байдлаар Монгол орны хэмжээнд байгаа газрын доорх усны мониторингийн 280 гаруй цэгийг энэхүү нэгдсэн сүлжээнд бүрэн холбоод байна. Хяналтын цооногуудыг сүлжээнд холбосноор газрын доорх усны ашиглалт, олборлолт, хэрэглээ, хур тунадасны хэмжээ зэргийг судалж, мэдэх боломж бүрдэж байгаа юм. Ингэснээр тухайн сав газар, компанийн ус ашиглалт, олборлолтын хэмжээг зохицуулах, хяналт тавих, зүй зохистой, нөөцөд тулгуурласан ашиглалтын горимыг мөрдүүлэх боломжтой болж байна. Түүнээс гадна томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг төлөвлөхдөө ч суурь судалгаа болгон ашиглаж болох юм.

Эх сурвалж: БОАЖЯ

Ж.БАТСУУРЬ: ХОТ, СУУРИН ГАЗРУУДЫН УНДНЫ УСНЫ ЧАНАРЫН СУДАЛГАА ХИЙЖ, НЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙН САНТАЙ БОЛНО




“...Олон улсын жишгээр авч үзвэл усны үнэ цэнийг үнэлэх боломжгүй гэж үздэг. Хүн уух усаар гачигдах юм бол ус ямар их үнэ цэнтэй байх нь ойлгомжтой. Бид үнэ гэж яриад сурчихсан байна л даа. Унд ахуйн усаар үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагууд үйлчилгээний зардлыг усны үнэ хэлбэрээр шингээж хэрэглэгчээс авч байгаа юм. Манай зохицуулах зөвлөлөөс цэвэр бохир усны үнэ тарифыг тогтоож байна. Унд, ахуйн ус бол харьцангуй хямд байгаа. Мөн усны найрлага, стандарт гэдэг маш чухал сэдэв байгаа юм. Хүний эрүүл мэндтэй шууд холбоотой. Иймээс ундны усны стандарт найрлагад онцгой анхаарал хандуулах шаардлагатай. Бид хот суурин газруудын ундны усны чанарын судалгаа хийж, нэгдсэн мэдээллийн сантай болохоор зорилт тавьж ажиллаж байна. Улаанбаатар

хотын 9 дүүрэгт зарим аймгуудад ундны усанд ашиглаж байгаа усны эх үүсвэрүүд, ус түгээх байрны ариун цэвэр зэргийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран судалгааны ажил хийж томоохон тайлангууд гаргаад байна. 2018 онд ундны усны стандартыг шинэчилж тогтоосон...”

Эх сурвалж: Усны үйлчилгээг зохицуулах зөвлөл

2021 ОНЫ ДЭЛХИЙН УСНЫ ХӨГЖЛИЙН ТАЙЛАНГ ТАНИЛЦУУЛЛАА



Жил бүрийн 3 дугаар сарын 22-ны өдөр дэлхийн нийтээрээ тэмдэглэн өнгөрүүлдэг Дэлхийн Усны өдөр өнөөдөр тохиож байна. Энэ өдөр НҮБ-ын Усны агентлагийн зүгээс уламжлал ёсоор Дэлхийн усны хөгжлийн тайланг танилцууллаа. Усны үнэ цэнэ, үнэлэмж нь усны нөөцийн сайн засаглалд зайлшгүй авч үзэх ёстой гол асуудлуудын нэг бөгөөд усны бүх талын хэрэглээг тооцож, бүрэн дүүрэн үнэлж чадахгүй байх нь усны нөөцийн буруу менежментийн үндэс суурь болдгийг тус тайланд онцолжээ. Тайлангийн дэлгэрэнгүйг <https://www.unwater.org/publications/un-world-water-development-report-2021/> холбоосоор орж үзэх боломжтой.

Эх сурвалж: unwater.org

ДЭЛХИЙН УСНЫ 9 ДҮГЭЭР ФОРУМ СЕНЕГАЛЫН ДАКАР ХОТНОО БОЛНО

Дэлхийн Усны Зөвлөлөөс зохион байгуулдаг 9 дэх Дэлхийн усны форум 2021 оны 3 дугаар сарын 22-ноос 27-ны өдрүүдэд Сенагал улсын Дакар хотноо болно. Энэхүү форум нь энэ жил анх удаа Африк тивд болж байгаа бөгөөд “Энхтайван байдал болон хөгжилд Усны аюулгүй байдлын гүйцэтгэх үүрэг” сэдвийн хүрээнд зохион байгуулагдана. Арга хэмжээний үеэр “Тогтвортой хөгжлийн зорилт 2030”-тай уялдаа бүхий усны аюулгүй байдал, хөдөөгийн хөгжил, хамтын ажиллагаа, холбогдох зорилтуудад хүрэх арга хэрэгсэл гэсэн чиглэлээр хэлэлцүүлэг өрнүүлэх юм байна.

Эх сурвалж: Дэлхийн Усны Зөвлөл

ТОВЧХОН

Зайсанд байрлалтай "Энхжин хотхон"-ны гүний худаг засварт орсны улмаас тус хотхоны 500 гаруй өрх дөрвөн хоногийн турш усгүй, зөөврийн усаар хэрэгцээгээ залгуулсан талаар LiveTV.mn мэдээлжээ. **Эх сурвалж: livetv.mn**